

**ӨӨРИЙН БОЛОН ХАНИЙН ЭЦЭГ ЭХ,  
АХАН ДҮҮС, ХАМААТАН САДАНГ  
АСРАН ЭНЭРЭХ**

# ТУЛГУУР ОЙЛГОЛТ

- **Эргүү мал-** ухаан мэдрэл дорой **Я.Цэвэл Монгол хэлний тайлбар толь**
- **Адаг мунхаг-**оюун ухаан нь гүйцэд задраагүй,эрүүл ухаанаа алдах
- **Хүй элгэн-**Ойрын садан **Аав ээж,үр хүүхдүүд Хадам ээж, аав**
- Хүй элгэн эвдрэлцвэл хөндлөн хүний идэш болно.
- **Ураг элгэн-**бүх хамаатан садан цөм **Хадам ээж аав,ах дүү нар, тэдгээрийн хүүхдүүд,дүү нар**
- **Хүй элгэн-Ураг элгэн**

# ОНОЛЫН ХЭСЭГ

- Хуулийн хариуцлага хугацаатай. Хүн буруу хэрэг хийвэл шоронд хугацаатай явуулдаг. Ёс суртахууны хариуцлагад хугацаа гэж байхгүй. Тийм ч учраас монголчууд “сайн нэрийг хүсэвч олдохгүй, муу нэрийг хусавч арилахгүй” гэх юм уу, “нэр хугарахаар яс хугар” гэж маш мэргэн онож хэлсэн байдаг. Энэ хүн муу хүн шүү, энэ хүн худалч, хулгайч хол яваарай гэж эцэг эх нь үр хүүхэддээ захисан бол энэ нь тэр хүнд оноож буй ёс суртахууны хариуцлага юм.
- Эрдэнийн Субашидад муу юм хичнээн олон боловч муу хүнээс илүү аюул гэж үгүй гэдгийг сануулсан байх аж. Ёс суртахууны доройтол, ёс суртахууны ялзрал нийгэмд асар их аюултай гэдгийг бид одоо тод харж байна.
- Хүүхдийн хэн болох нь гэр бүлийн орчноос 70 хувь хамаардаг гэсэн тооцоо ч байдаг аж.

# Дасгал 1,2 ажиллах

Эцэг эхээ үл хүндлэгч  
Эргүү малаас ялгаа юун  
Эцэг эхээ үл асрагч  
Хүмүүний адаг мунхаг буюу

Хүй элэгнээс хагацваас  
Хөндлөн хүмүүний идэш болмуй  
Ураг элэгнээс хагацваас  
Харь дайсны боол болмуй

Өөрийн болон ханийн эцэг эхээ  
асран энэрдэггүй хүнийг хамгийн  
ухаан муутай хүн хэмээн монголчууд  
тооцдог ажээ.

Өөрийн болон ханийн эцэг эх, ах  
эгч дүү, хамаатан садан, төрөл  
төрөгсдөөсөө холдож хөндийрвөл  
бусдад дорд үзэгдэх шалтгаан үүсдэг  
тул тэдэнтэйгээ эв түнжинтэй байж,  
асран энэрэх сэтгэлээр халуун  
дулаан сэтгэлийг үүсгэх хэрэгтэй гэж  
монголчууд үздэг байна.

## Дасгал 2



*Дараах сургаал шүлгийг<sup>102</sup> уншаад доорх асуултад хариулж  
ярилцаарай.*

Ахас өтгөсөө хүндлэн дагах  
Айл гэрийн ёс төр буй за.  
Муу эр эхнэртээ

Эрэлхүү дээрэлхүү аж  
Мунхаг эм хадамдаа  
Элгэн эс болох аж

Асуулт:

1. Айл гэрт “төр ёс” гэж байх уу?
2. Эхнэртээ дээрэлхүү эр хүнийг юу гэж дүгнэдэг вэ?
3. “Хадамдаа элгэн болох” гэж юу гэсэн үг вэ?

# ХАДАМ ЭЭЖТЭЙГЭЭ ХАРИЛЦАХ ДҮРЭМ

1. Хадам ээжийгээ ямар ч тохиолдолд зүгээр л ээж гэж дуудна.
2. Баяр ёслол болон төрсөн өдрөөр нь хамгийн түрүүнд баяр хүргэнэ.
3. Хадам ээжийнхээ эрүүл мэндэд байнга санаа тавьж, өвдсөн тохиолдолд сэтгэлээсээ асарч сувилна.
4. Хэзээ ч түүнтэй дээрэнгүй, өндөрсгөсөн дуугаар харьцахгүй.
5. Хэрвээ хань чинь ээжтэйгээ маргалдвал хэзээд хадам ээжийнхээ талд орно.
6. Хадам ээждээ өөрийн гараар түүнд зориулж ямар нэг зүйл хийж бэлэглэнэ.
7. Түүн рүү ойр ойрхон утасдаж, мэндчилж, эрүүл мэндэд нь санаа тавина.
8. Хадам ээжийгээ найз нөхөд, танилууд, хөршүүддээ хэзээ ч муучлахгүй.
9. Түүнд хэзээ ч ханийгаа муулж ховлохгүй.
10. Хадам ээждээ магтаалын үг байнга хэлнэ.
11. Хадам ээжээсээ хэзээ ч мөнгө зээлэхгүй, зээлсэн тохиолдолд хурдан буцааж өгнө.
12. Түний эд зүйлсээс өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр юуг ч хаяхгүй.
13. Хэрвээ та тусдаа амьдардаг бол хааяа ирж гэрийг нь цэвэрлэж өгч байна.
14. Хадам ээжийнхээ гаргадаг зан аашинд тэвчээртэй хандана.
15. Зочид олноор цугларсан үед хадам ээждээ талархал илэрхийлж байна.

# БИЧЛЭГ ҮЗЭХ

- <https://www.facebook.com/watch/?v=3216910238381202>
- Дүүгээ Дауны хам шинжтэй гэдгийг мэдсэн.
- <https://www.facebook.com/watch/?v=3147360885536190>
- Хадам аавыгаа баярлуулсан бичлэг

# ГЭР БҮЛИЙН ЗУРАГ АВАХУУЛАХ САНАА



# ОЛОН УЛСЫН ГЭР БҮЛИЙН ӨДӨР

- НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1994 онд жил бүрийн 5 сарын 15-ны өдрийг “Олон улсын Гэр бүлийн өдөр” хэмээн зарласан. Гэр болох нь хариуцлага юм.





## ХОЁРДУГААР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Хүүхдүүд та бүхэн бүгд л ирээдүйн сайхан гэр бүлийн эзэн, эзэгтэй нар, аав ээжүүд болж, улс орондоо, ард түмэндээ хэрэгтэй ажил мэргэжлийг сонгон эзэмших нь мэдээж. Гэхдээ хүн ажил амьдралаа зохицуулах тал дээр олон асуудал тулгардаг. Ажиллахын тулд амьдрах уу, амьдрахын тулд ажиллах уу гэсэн асуултад утга учиртай хариултыг олох хэрэгтэй болно. Сайхан амьдрахын тулд тууштай, чин сэтгэлээсээ, сайн ажиллах хэрэгтэй, гэхдээ хамгийн их ачаалалтай ажиллаж байх үедээ ч ойр дотны хүмүүстээ, гэр бүлдээ, үр хүүхдэдээ хангалттай цаг гаргах шаардлагатай. Бас хэт ачаалалтай ажиллах нь эрүүл мэндийг муутгана. Иймээс ажлаа чанартай сайн гүйцэтгэхийн хамт гэр бүлдээ болон өөртөө анхаарал тавих цагийг гаргаж байхаар ажил амьдралаа зохицуулж сурах нь чухал. Таны ажил ч, амьдрал ч танд болон ойр дотны хүмүүст сэтгэл ханамж, аз жаргалыг авчирч байвал, та нийгмийн төлөө, хүмүүсийн төлөө, ойр дотныхныхоо төлөө өөрийгөө зориулж, асрал энэрлээр хандаж байвал та зөв явж байна гэсэн үг.

# СУРАГЧДЫГ ШАЛГАХ

- Ментиметрээр ойлгосон мэдлэгээ шалгах

# **ГЭРИЙН ДААЛГАВАР**

**“МИНИЙ АМЬДРАЛЫН АЗ ЖАРГАЛ” ЭСЭЭ БИЧИХ**